



**“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ**

**“ХЭВЛЭХ ЦЕХИЙН ЦААС, ЦААСАН БҮТЭЭГДЭХҮҮН”  
НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалт: Хэвлэх цехийн цаас, цаасан бүтээгдэхүүн**

**Тендер дугаар: ЭХХТ/201906001**

**Улаанбаатар хот  
2019 он**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Тендерийн нэр: **“Хэвлэх цехийн цаас, цаасан бүтээгдэхүүн”**

Тендерийн дугаар: **ЭХХТ/201906001**

“Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Хэвлэх цехийн цаас, цаасан бүтээгдэхүүн” нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Үнийн саналыг **2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг **2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 10 цаг 30 минутад** тендерийн нээлтийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-хороо, Чингисийн өргөн чөлөө-45.

“ЭХХТ” ТӨҮГ өөрийн байр. 207 тоот Утас: 88064321

Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)

	Хоёр.	<b>ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА</b>
<b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b>	1.1.	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
<b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>	2.1.	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
	2.2.	Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
	2.3.	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
<b>3. Тендерийн иж бүрдэл</b>	3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд: (а) Үнийн санал; (б) Үнийн бол нийлүүлэлтийн хуваарь; (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг; (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
<b>4. Тогтмол үнэ</b>	4.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
<b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b>	5.1.	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
	5.2.	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
<b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>	6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт ирүүлэх</p> <p>2. Сүүлийн 2 жилд 2017,2018 онд ижил төстэй бараа нийлүүлсэн тухай мэдээлэл ирүүлэх /гэрээний хуулбар, барааг хүлээлгэн өгсөн акт, нотариатаар баталгаажуулсан/.</p> <p>3. Харьяа дүүргийн татварын хэлтэс, нийгмийн даатгалын хэлтэс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас тодорхойлолт ирүүлэх</p> <p><b>Нэмэлт шаардлага</b></p> <p>1. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</p> <p>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ</p> <p>3. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх</p> <p><b>Төсөвт өртөг: 45,326,000 төг</b></p> <p>4. Бараа нийлүүлэх хугацаа /Гэрээний дагуу /</p> <p>5. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.</p> <p>Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын"-ын дагуу "татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана".</p> <p>6. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.</p> <p>7. Гадаад хэл дээрх материалыг албан ёсны эрх бүхий орчуулгын төвийн тамга, тэмдэгээр баталгаажсан Монгол хувилбарын хамт ирүүлнэ.</p> <p>8. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг нотлох баримт бичгийг тендерийн хамт ирүүлнэ.</p> <p>9. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. (Гэрээ хийгдсэнээс хойш 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл <b>/3,4 дүгээр улирал/</b>)</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө, "ЭРЧИМ ХҮЧНИЙ ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ өөрийн байр, 2давхарт 207 тоот. <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>. Цахим хэлбэрээр авна. Огноо: <b>2019 оны 07 дугаар сарын 04-ний өдөр</b> Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Цахимаар нээнэ. Огноо: <b>2019 оны 07 дугаар сарын 04-ний өдөр</b> Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b></p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт

Цаасны төрөл	Жин гр/м <sup>2</sup>	Хэвлэлийн формат	Цаасны хэмжээ /мм/
Номын хөнгөн шар	70 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	80 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
Номын гөлгөр шар	68 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	78 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
Офсет	60 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	70 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	80 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	100 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	120 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
Шохойтой цаас	80 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	90 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	100 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	105 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	128 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	157 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	200 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	250 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	300 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
350 гр/м <sup>2</sup>	A0	889*1194	
Матт цаас	80 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	90 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	100 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	105 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	128 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	157 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	200 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	250 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
	300 гр/м <sup>2</sup>	A0	889*1194
1-р өнгө /цагаан/	48 гр/м <sup>2</sup>	A1	889*615
2-р өнгө /ягаан, ногоон, шар, цэнхэр/	50 гр/м <sup>2</sup>	A1	889*615
3-р өнгө /ягаан, ногоон, шар, цэнхэр/	47 гр/м <sup>2</sup>	A1	889*615
A3 бичгийн цаас	70 гр/м <sup>2</sup>	A3	297*440
	80 гр/м <sup>2</sup>	A3	297*440
Бүрэлт /гялгар/	23	-	440*2000
Бүрэлт /матт/	23	-	440*2000

## 2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

- Худалдан авалтыг тухай үеийн хэрэгцээнээс хамаарч нийлүүлнэ

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойл олт	Тоо шир хэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэг чийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Номын хөнгөн шар	889*1194		70 гр/м2	Эрчим хүчний хөгжлийн төв	2019.07.01	2019.12.31	
	889*1194		80 гр/м2				
Номын гөлгөр шар	889*1194		68 гр/м2				
	889*1194		78 гр/м2				
Офсет	889*1194		60 гр/м2				
	889*1194		70 гр/м2				
	889*1194		80 гр/м2				
	889*1194		100 гр/м2				
Шохойтой цаас	889*1194		120 гр/м2				
	889*1194		80 гр/м2				
	889*1194		90 гр/м2				
	889*1194		100 гр/м2				
	889*1194		105 гр/м2				
	889*1194		128 гр/м2				
	889*1194		157 гр/м2				
	889*1194		200 гр/м2				
	889*1194		250 гр/м2				
Матт цаас	889*1194		300 гр/м2				
	889*1194		350 гр/м2				
	889*1194		80 гр/м2				
	889*1194		90 гр/м2				
	889*1194		100 гр/м2				
	889*1194		105 гр/м2				
	889*1194		128 гр/м2				
	889*1194		157 гр/м2				
889*1194		200 гр/м2					
889*1194		250 гр/м2					
889*1194		300 гр/м2					
1-р өнгө /цагаан/	889*615		48 гр/м2				
2-р өнгө /ягаан, ногоон, шар, цэнхэр/	889*615		50 гр/м2				
3-р өнгө /ягаан, ногоон, шар, цэнхэр/	889*615		47 гр/м2				
А3 бичгийн цаас	297*440		70 гр/м2				
	297*440		80 гр/м2				
Бүрэлт /гялгар/	440*2000		23				
Бүрэлт /матт/	440*2000		23				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

Эрчим хүчний хөгжлийн төвийн захирал А.Бямбадорж танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-ээс гэрээг цуцлах          | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуу хийнэ:
1. **Урьдчилгаа төлбөр:** Урьдчилсан төлбөр олгохгүй
  2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** бараа ачигдсаны дараа төлбөр төлөхгүй.
  3. **Барааг хүлээн авах төлөх төлбөр:** Ирсэн барааны төлбөрийг нэхэмжлэлийн дагуу үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор захиалагчтай хийгдсэн гэрээний дагуу төлбөрийг төлнө.
- Захиалагч Монгол Улсын дотроос санал болгосон барааны төлбөрийг дараах журмын дагуу хийнэ:
1. **Урьдчилгаа төлбөр:** Урьдчилсан төлбөр олгохгүй.
  2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Бараа ачигдсаны дараа төлбөр төлөхгүй.
  3. **Барааг хүлээн авах төлөх төлбөр:** Ирсэн барааны төлбөрийг нэхэмжлэлийн дагуу үнийн 100 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор захиалагчтай хийгдсэн гэрээний дагуу төлбөрийг төлнө
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup> 9.1. Алданги оногдуулах хувь: **0,5%**
- Алдангийн нийт дүн: **10**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -аас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*